


Ерөнхийлөгч Томас С.Монсон



Бид бэлтгэлтэй байна уу?

Сүм миний амьдарч мөн үйлчилдэг байсан газарт тахианы аж ахуйн төсөл хэрэгжүүлдэг байсан бөгөөд ажилчдын ихэнх нь орон нутгийн тойргуудын сайн дурынхан байлаа. Энэ төсөл нь ихэнхдээ үр ашигтай байсан бөгөөд бишопын агуулахыг олон мянган өндөг, хэдэн зуун кг тахианы махаар хангадаг байв. Хэдийгээр сайн дурын, хотын аж ахуйн фермерүүд байсан ч гэсэн заримдаа ажлын ачааллаас болоод гар цэврүүтэх байтугай сэтгэл санаагаар унах явдал ч гардаг байлаа.

Бид нэгэн удаа төслийнхөө ажлын хаврын цэвэрлэгэнд Аароны санваартан залуу эрэгтэйчүүдийг цуглуулан оролцуулж байсныг би үргэлж санан дурсах болно. Эрч хүчтэй, урам зоригтой манай залуус нэг дор цугларч, хогийн ургамал, хог хаягдлыг хурдан шуурхай үндсээр нь зулгааж, хурааж мөн шатаасан юм. Бид түүдэг гал дээр шарсан зайдас идэж, ажлаа сайн хийсэндээ баясан, бие биедээ баяр хүргэж билээ.

Харамсалтай нь, нэгэн том асуудал үүссэн юм. Тэрхүү их дуу чимээ, гал зэрэг нь эмзэг мэдрэмтгий 5000 эм тахиаг тун их цочроосны улмаас ихэнхийнх нь өдсөд унаж, өндөглөхөө больсон байлаа. Түүнээс хойш тэднийг илүү их өндөглөдөг болгохын тулд бага зэрэг хогийн ургамал үлдээж байх хэрэгтэй юм байна гэдгийг бид хүлээн зөвшөөрч билээ.

Тусламж хэрэгтэй хэн нэгэнд тусалсан сүмийн ямар ч гишүүн олж авсан туршлагаа мартаж юм уу түүндээ хэзээ ч харамсдаггүй. Хичээл зүтгэлтэй, арвиг хямгач, бие

даасан байх болон бусадтай хуваалцах зэрэг нь бидний хувьд шинэ зүйл биш юм.

Сүм дэх гэр бүл бүр хоол хүнс, хувцас хунар, амьдралын хэрэгцээт бүх л боломжтой зүйлийг нөөцлөх нь агуулахын хамгийн сайн арга гэдгийг бид санаж явах хэрэгтэй. Их Эзэний агуулах нь сүмийн итгэлтэй гишүүдийн цаг хугацаа, авьяас билэг, ур чадвар, энэрэл, ариулан адислагдсан эд материал, санхүүгийн арга хэрэгсэл зэргийг багтаадаг юм. Эдгээр нөөц нь бишопыг тусламж хэрэгтэй хүмүүст туслах боломжтой болгодог.

Бид бүх хожмын үеийн гэгээнтэнг ухаалаг төлөвлөж, арвиг хямгач амьдрах, шаардлагагүй хэт их өр зээлээс зайлсхийхэд уриалж байна. Хоол хүнс, хувцас хунар нөөцөлж, өр тавихгүй байснаар тохиолдож болох санхүүгийн хямралыг маш олон хүн даван гарах болно. Гэвч өнөөдөр олонх нь өр зээл хийх, хоол хүнс нөөцлөхгүй байх зэргээр уг зөвлөгөөг үл тоомсорлосоор байна.

Хэдэн жилийн өмнө Тэргүүн Зөвлөлөөс:

“Хожмын үеийн гэгээнтнүүдэд бага багаар мөнгө хадгалснаар зовлон бэрхшээл тохиолдох үед бэлтгэлтэй байх тухай олон жилийн турш зөвлөж ирсэн. Уг зөвлөгөөг дагах нь хэмжээлшгүй их хамгаалалт, сайн сайхан амьдралыг авчрах болно. Гэр бүл болгон чадах чинээгээрээ өөрийн хэрэгцээг хангах үүрэг хариуцлага хүлээх хэрэгтэй.

Бид та бүхнийг дэлхийн хаана амьдарч байгаагаасаа үл шалтгаалан өөрсдийнхөө санхүүгийн нөхцөл

байдалд анхаарлаа хандуулж, зовлон бэрхшээлд бэлтгэлтэй байхад зоригжуулж байна. Мөн үрлэг зарлагадаа даруухан байж, өр тавилгүй юм худалдаж авдаг байхад суралцаасай гэж та нараас хичээнгүйлэн хүсэж байна. Өр зээлээ аль болох түргэн буцаан төлж, өөрсдийгөө боолчлолоос чөлөөл. Бага хэмжээний мөнгийг тогтмол хадгалснаар аажмаар санхүүгийн нөөцтэй бол” хэмээн тунхагласныг би давтан хэлбэ.¹

Бид амьдралдаа тохиолдож болох гэнэтийн нөхцөл байдалд бэлтгэлтэй байна уу? Бид ур чадваруудаа хөгжүүлж байна уу? Бидэнд ямар нэг нөөцөлсөн зүйл байгаа юу? Бид Бурханы зарлигуудад дуулгавартай байна уу? Бид бошиглогчдын заасан зүйлсийг дагаж байгаа юу? Бид ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүст туслахад бэлтгэлтэй байна уу? Бид Бурханд шударга байна уу?

Өнөөдөр бид бэрхшээлээр дүүрэн цаг үед амьдарч байна. Ирээдүйд юу болохыг тааж мэдэх аргагүй юм. Тиймээс тааж болшгүй зүйлсэд бид бэлэн байх хэрэгтэй. Шийдвэр гаргах цаг ирэхэд бэлтгэх цаг хэдийн өнгөрчихсөн байх болно.

ЭШЛЭЛ

1. Тэргүүн Зөвлөл, *Бүх зүйл аюулгүйгээр хураагдсан: Гэр бүлийн төсөв* (Товхимол, 2007).

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Айлчлан очиж буй хүмүүсийнхээ хэрэгцээг анзаарч, тэдэнд ажил эрхлэх, санхүүгийн болон хүсний нөөц хийх эсвэл гэнэтийн нөхцөл байдалд илүү бэлтгэлтэй байх зэргээр бие даах чадвартай болоход нь хэрхэн туслах арга замуудын талаар бод. Тэднийг ерөнхийлөгч Монсоны зөвлөгөөг дагахад дэмжлэг үзүүлж, цэцэрлэгжүүлэх, мөнгө санхүүгээ зөв зохицуулах зэрэг мэдлэг чадвараасаа хуваалцах талаар тунгаан бодно уу.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Би дахин үйлчилсэн

Жэйн Араюжо

Би нэг өдөр үйлчлэлийн ажлаа хийж дуусгаад сүмийнхээ цуглааны байрны хажуугаар өнгөрөн

явж байхдаа цуглааны байрыг цэвэрлэж буй хоёр эгчийг харсан юм. Би өөрийн эрхгүй “Эгч нар аа, та нарт туслах уу?” гэж асуухад тэдний нэг нь над руу инээмсэглээд бид хоёулхнаа цэвэрлээд маш их ядарч байсан юм, харин чи яг цагаа олж ирлээ гэж хэлэв. Тэрээр Их Эзэнд хандан, туслах хэн нэгэн хүнийг илгээгээч хэмээн залбирсан байжээ. Би залбирлынх нь хариулт болсондоо ихэд баярлаж билээ. Би үйлчлэлийн ажлаа дөнгөж дуусгаад явж байсан болохоор их ядарсан байсан ч зүрх сэтгэлээ даган, илүү их үйлчлэхийг хүссэн юм.

Баяр баясгалантай үйлчлэх нь тушаал юм (С ба Г 24:7-г үзнэ үү). Бид бүх цаг үед үйлчлэх хүсэлтэй байснаар бусдын амьдралд гайхамшиг тохиолдоход тусалж чадна. Биднийг үйлчлэх үед амьдрал маань илүү утга учиртай болдог. Их Эзэн үнэхээр биднийг хайрладаг бөгөөд өөрийнхөө хүүхэд бүрд тусалж, үйлчлэх хүчийг өгдөг билээ.

Зохиогч нь Бразилийн Рио Гранд до Нортод амьдардаг.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Та бэлтгэлтэй байна уу?

Хариултууд: үнэн, үнэн, худал, үнэн, худал

Ерөнхийлөгч Монсон хэцүү цаг үедэд өөрсдийгөө бэлтгэхийг мөн хүнд хэцүү үед нь бусдад туслахыг бидний хүн нэг бүрээс хүссэн юм. Та дараах асуултад үнэн эсвэл худал хэмээн хариулж, бэлтгэлтэй байгаа эсэхээ мэдэж ав!

Би тусламж хэрэгтэй хэн нэгнийг үргэлж олж чаддаг. Үнэн Худал

Би өөрт байгаа бүх зүйлдээ талархаж чадна. Үнэн Худал

Надад хэн нэгэнтэй хуваалцах авьяас чадвар байхгүй. Үнэн Худал

Ирээдүйдээ зориулж мөнгө хадгалах нь зөв санаа юм. Үнэн Худал

Би аз жаргалтай байхын тулд шинэ тоглоом болон хувцас хунар худалдаж авах хэрэгтэй. Үнэн Худал

© 2014 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/14. Орчуулгын зөвшөөрөл: 6/14. *First Presidency Message, September 2014.* Mongolian. 10869 363-ын орчуулга



Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Тайтгаруулагч

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд эрэлхийлж хай. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн өсгөж, айлчлагч багшийн ажлаар дамжуулан өөрийн тань харж хандан, анхаарал тавьдаг хүмүүсийн амьдралыг хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг reliefsociety.lds.org вэбсайтаас үзнэ үү.

Итгэл, гэр бүл, халамж

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудыг агуулсан айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

Есүс Христ: “Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та наруу ирнэ” (Иохан 14:18) хэмээн амласан. Тэрээр бидэнд “үнсний оронд цэцгийн хэлхээг өгч, гацуудын оронд баяр хөөрийн тосыг соёрхох болно” (Исаиа 61:3). Христ бидний хүн нэг бүрийн төлөө Цагаатгал хийсэн учраас Тэрээр биднийг мартахгүй. “Бидний Аврагч Өөр дээрээ бидний өвчин шаналал, зовлон зүдгүүрийг авсан учраас бидний юу мэдэрч байгааг мөн биднийг хэрхэн тайтгаруулахаа мэддэг” хэмээн Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Линда С.Рийвс хэлсэн.¹

Христ биднийг тайтгаруулна гэх мэдлэг нь бидэнд амар амгаланг өгч, биднийг Түүний үлгэр жишээгээр бусдад туслахад урамшуулдаг. Ерөнхийлөгч Томас С. Монсон “Биднийг шулуун алхаж, зарлигуудыг дагах үед сайн мэдээний талаарх мэдлэг мөн Тэнгэрлэг Эцэг болон Аврагчийг хайрлах

хайр маань биднийг тайтгаруулан дэмжиж, зүрх сэтгэлд баяр баясал авчирдаг. Энэ дэлхий дээр биднийг ялах ямар ч зүйл байхгүй байх болно”² хэмээн хэлсэн.

Судруудаас

Иохан 14:18, 23; Алма 7:11–13; Сургаал ба Гэрээ 101:14–16

Бидний түүхээс

Халамжийн Нийгэмлэгийн 12 дахь ерөнхийлөгч Элэйн Л.Жэк “Бид айлчлагч багшийн дуудлагат ажлаа хийснээр нэг нэгэндээ хүрч, тусалж чаддаг билээ. Бидний үйлдлүүд ихэнхдээ бидний үгээр илэрхийлж чадахгүй зүйлсийг харуулж байдаг. Халуун дотно байдлаар тэврэх нь их зүйлийг илэрхийлдэг. Хамт инээлдэх нь ч мөн биднийг нэгтгэдэг. Бие биетэйгээ хуваалцах, ярилцах мөч бүр нь бидний сэтгэлийг сэргээж байдаг билээ. Бид хүнд хэцүү байдалд буй хүний ачааг үргэлж үүрч чадахгүй ч ачаагаа хөнгөхөн дааж чадахуйц байж болохын тул түүнд сэтгэлийн дэм үзүүлж өргөж чадна”³ гэж хэлжээ.

Халамжийн Нийгэмлэгийн анхдагч эгч нар “нэг нэгнийхээ хайр, энэрлээс сүнслэг хүч чадлыг олж авдаг байв. . . . Тэд өвчин, үхлээс болж шаналж байхдаа нэг нэгнийхээ төлөө итгэлтэй залбирч, бие биеэ тайтгаруулдаг байсан. ‘Ёс бус тэр нь Их Эзэн болон бидний хоорондын харилцаанд хорон санаат хатгууруудаараа нөлөөлж чадахгүй болтол мөн түүний оролдлого уйтгар гунигийг авчирч чадахгүй мэт санагдтал Бурханы хайр зүрхнээс зүрхэнд юүлдэг’ хэмээн Хэлэн Мар Витнэй бичсэн байдаг.”⁴

ЭШЛЭЛҮД

1. Линда С.Рийвс, “Их Эзэн таныг мартаагүй,” *Ensign* эсвэл *Луахона*, 2012 оны 11-р сар, 120.
2. Томас С.Монсон, “Зоригтой бай,” *Ensign* эсвэл *Луахона*, 2009 оны 5-р сар, 92.
3. Элэйн Л.Жак, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 119.
4. *Daughters in My Kingdom*, 34.

Үүнийг эргэцүүлэн бод

Их Эзэн таныг санадаг гэдэг ойлголт таныг хэрхэн тайвшруулдаг вэ?